



Ерөнхийлөгч Томас С.Монсон

“Би чамайг хаяхгүй, мөн чамайг орхихгүй”

Гарцаагүй туулах ёстой сорилтуудтайгаа тулгарч мөн даван туулснаар бид суралцаж, өсч хөгжин, илүү хүчирхэг болдгийг Тэнгэрлэг Эцэг маань . . . мэддэг.

Энэ орой өөрийн тэмдэглэлдээ би “Энэ хуралдаан миний оролцож байсан ерөнхий чуулгануудын хамгийн сүнсэлэг нь байлаа. Бүх юмс хамгийн агуу, хамгийн сүнсэлэг байдалтай байлаа” гэж бичих болно.

Ах, эгч нар аа, бид зургаан сарын өмнө Ерөнхий чуулганаар энд цуглаад байхад миний эхнэр Франсис чуулган эхлэхээс хэдхэн хоногийн өмнө маш эвгүй унаж, бэртсэний улмаас эмнэлэгт хэвтэж байсан юм. Тэр маань таван сард, нэлээн хэдэн долоо хоног эдгэх гэж цуцалтгүй тэмцсэний эцэст бэртлүүдээ даалгүй, мөнхийн оронд одсон билээ. Түүнийгээ алдах аймшигтай байлаа. Би түүнтэй 1948 оны 10-р сарын 07-нд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн юм. Маргааш бид хоёрын гэрлэсний 65 жилийн ой болох юм. Эхнэр минь миний амьдралын цорын ганц хайр, хамгийн сайн итгэмжит нөхөр мөн хамгийн дотны минь найз

байсан. Би түүнийгээ үгээр илэрхийлэхийн аргагүй ихээр санаж байна.

Ерөнхийлөгч Давид О. Маккэй намайг Арванхоёр Төлөөлөгчийн чуулгад дуудсаны 50 жилийн ой энэ чуулганаар тохиож байна. Энэ олон жилийн турш хайрт эхнэр минь намайг бүрэн дүүрэн дэмжиж ирсэн юм. Надад дуудлагаа хийх боломж олгохын тулд тэр тоолж барамгүй их золиослол гаргадаг байж билээ. Нэлээн хэдэн өдрөөр, заримдаа бүр хэдэн долоо хоногоор түүнийгээ хүүхдүүдтэй нь хамт орхин явах шаардлага гарахад ганц ч удаа гомдлын үгс унагаж байгаагүй юм даг. Тэр минь, яалт ч үгүй, тэнгэр элч байсан юм.

Франсисыг минь нас барахад надад болон гэрийнхэнд маань үзүүлсэн тэр их агуу хайрын төлөө би талархлаа илэрхийлье. Дэлхийн өнцөг булан бүрээс эхнэрийг минь дурссан, намайг тайтгаруулсан зуун зуун ил захидал болон захиа ирж

байсан. Хэдэн арван үзэсгэлэнтэй цэцгийн баглааг бид хүлээж авсан билээ. Түүнчлэн эхнэрийн маань дурсгалд зориулж, сүмийн номлогчийн ерөнхий санд олон тооны хандив өргөсөн та бүхэнд бид талархаж байна. Эхнэрийн минь ардаа үлдээгээд явсан бүх хүмүүсийн өмнөөс би та нарын чин сэтгэлд маш их баярласнаа илэрхийлэхийг хүсэж байна.

Түүнээсээ хагацсан тэрхүү мөчид Есүс Христийн сайн мэдээний талаарх миний гэрчлэл болон хайрт Франсис минь амьдарсаар байгаа гэдэг мэдлэг намайг үнэхээр их тайвшруулж байсан. Бид түр салцгаагаад байгаа гэдгээ би мэднэ. Газарт болон тэнгэрт лацдах эрх мэдэлтэй нэгнээр Бурханы гэрт бид хоёр лацдан холбогдсон гэдгийг би мэднэ. Нэгэн өдөр бид хоёр дахин хэзээ ч салахгүйгээр нэгдэнэ гэдгийг ч би бас мэднэ. Энэ мэдлэг л намайг хүчирхэгжүүлж байна.

Ах, эгч нар аа, зовлон, гашуудал туулалгүй амьдарсан нэг ч хүн үгүй мөн хүмүүний түүхэнд үймээн самуун, гаслан зовлон тохиолдоогүй нэг ч мөч байхгүй гэж хэлэхэд үнэнээс нэг их гажихгүй байх.

Амьдрал биднийг ганц сайн сэгсрэхэд “Яагаад заавал намайг гэж?” хэмээн асуумаар үе тохиолддог. Заримдаа хонгилын үзүүрт бүртийх ч гэрэл харагдахгүй; шөнийн харанхуйг эвдэн, нар хэзээ ч дахин мандахгүй юм шиг санагдах үе ч ирнэ. Ийм үед мөрөөдөл замхран алга болох үеийн гансрал, найдвар алдагдах үеийн цөхрөл хоёроос өөр юу ч үлдээгүй юм шиг санагдаг. Библид гардагчлан “Гилеадад

ямар ч гавар байхгүй гэж үү?”¹ хэмээх цөхрөлийн үгсийг бид бувтнадаг. Бид хэнд ч хэрэггүй, уй гашууд дарагдсан, ганцаардсан нэгэн болон хувирна. Бидэнд тохиолдоод байгаа золгүй явдлуудаа гутранги үзэлтний томруулдаг шилээр харах хандлага ч ажиглагддаг. Асуудлаа шийдэх гэж яаран, тэнгэрлэг зан чанар - тэвчээртэй байдал гаргах хэрэгтэй гэдгээ бид мартдаг билээ.

Бидэнд тохиолдох бэрхшээлүүд тэсвэр тэвчээрийг маань сорьсон жинхэнэ шалгалт болдог. “Бууж өгөх уу эсвэл эцэст нь хүргэх үү?” гэдэг хамгийн чухал асуултад бид өөрсдөө л хариулах ёстой. Бидний зарим маань асуудлаа шийдэж чадахгүй, бууж өгдөг. Харин эцэст нь хүргэнэ гэдэг нь амьдралынхаа төгсгөл хүртэл хичээсээр байхыг хэлнэ.

Тохиолдож буй явдлуудынхаа талаар эргэцүүлэн бодохдоо бид Иовын адил “хүн зовлонгийн төлөө л төрдөг”² гэж хэлцгээж болно. Иов бол “гэм зэмгүй, шулуун шударга” хүн байсан бөгөөд тэрээр “Бурханаас эмээдэг болоод бузар муугаас зайлдаг”³ нэгэн байсан. Зөв шударгыг үйлдэгч, хөрөнгөө өсгөн нэмэгдүүлж чадсан Иов хэнийг ч устгаж чадах тийм хэцүү даалгаврыг давах хэрэгтэй болдог. Хамаг хөрөнгөө алдаж, найз нараараа доромжлуулсан, зовлонд унаж, гэр бүлээ алдан, цөхрөнгөө барсан түүнд “Бурханыг хараагаад, үхэх”⁴ л зам байсан. Гэвч тэрээр тэрхүү уруу таталтад автагдалгүй, өөрийнхөө сүрлэг сайхан сэтгэлийн гүнээс:

“Харагтун, Миний гэрч тэнгэрт, миний өмгөөлөгч өндөрт байна.”⁵

“Миний Золигч амьд гэдгийг би мэднэ”⁶ хэмээн тунхагласан юм.

Иов итгэлтэй үлдсэн. Бидэнд ирэх зовлон бэрхшээлүүдтэй нүүр тулахдаа бид ингэж чадах болов уу?

Амьдралын нугачаанд нухлагдан, сөхрөх үедээ бусад хүмүүс ч гэсэн энэ замыг туулж, тэвчиж мөн ялан гарсан гэдгийг санацгаая.

Энэ үед буюу сайн мэдээний бүрэн дүүрэн байдлын үед асуудалтай тулгарсан ч тууштай мөн

өөдрөг хэвээрээ үлдэж чадсан хүмүүсийн талаар сүмийн түүхэнд зөндөө гардаг. Тэд яаж ингэж чадсан юм бол? Есүс Христийн сайн мэдээ тэдний амьдралын цөм нь болсон байдаг юм. Юу ч тохиолдсон, сайн мэдээ л бидэнд зовлон бэрхшээлээ даван туулахад тулсална. Хүнд бэрх үе ирж л таарна, гэвч бид толгойгоо бөхийлгөлгүй зогсож, зоригтой байснаар эцэст нь тэдгээрийг ялан дийлдэг билээ.

Зовлонд нухлуулан, дэрэн дээрээ нулимс дуслуулан хэвтэж байхад минь “Би чамайг хаяхгүй, мөн чамайг орхихгүй”⁷ гэх тэнгэрлэг бөгөөд үнэт амлалт биднийг дээш өргөн, босгох болно. Ийм тайтгарлыг үнэлэхийн аргагүй билээ.

Дуудлагат ажлаа хийн, дэлхий даяар аялж байхдаа би олон зүйлийг—тэр дундаа уй гашуу, зовлон бэрхшээл гэдэг чинь хаа ч гэсэн байж л байдаг юм байна гэдгийг олж мэдсэн юм. Уй гашууд автсан, өвдөж шаналсан, эхнэр эсвэл нөхрөөсөө салж байгаа, замаа алдсан хүүхдийнхээ төлөө сэтгэл зовон суугаа эсвэл нүглийнхээ үр дагаврыг амсан зовж байгаа хүмүүстэй уулзахад зүрх минь хэрхэн шаналж, сэтгэл минь хэрхэн өвддөгийг тайлбарлах боломжгүй юм. Бидэнд ирж болох зовлон бэрхшээлүүдийг бүтдийг тоочих ч аргагүй билээ. Энэ олон зовлон дундаас тодорхой нэгэн жишээг онцлон хэлэх хэцүү ч зовлон бэрхшээлийн талаар бодох тоолонд, намайг бага байхад ням гарагийн хичээл заадаг байсан Бремз ах санаанд минь ордог юм. Тэрээр алтан зүрхтэй, сүмийн итгэлтэй гишүүн байсан юм. Түүний эхнэрийг Сэйди гэдэг байсан бөгөөд тэд бидэнтэй ойролцоо насны 8 хүүхэдтэй байж билээ.

Франсис бид хоёр гэрлээд тэр тойргоос явсны дараа ч бид Бремз ах, эгчийн гэр бүлтэй хурим найр, оршуулганд эсвэл тойргийн уулзалт дээр тааралддаг байв.

1968 онд Бремз ахын эхнэр Сэйди нь нас барж мөн хэдхэн жилийн дотор түүний 8 хүүхдийн 2 нь

нас барсан юм.

Бараг 13 жилийн өмнө, нэгэн өдөр Бремз ахын ач охин нь над руу залгаж билээ. Тэрээр надад өвөө нь 105 наслаад байгааг хэлсэн юм. Тэр охин “Өвөө маань ахмад настангуудыг асардаг жижиг төвд амьдарч байгаа. Гэсэн ч ням гараг бүр өвөө маань гэр бүлийнхнийгээ цуглуулж, сайн мэдээнээс хуваалцдаг” гэж хэлээд үргэлжлүүлэн, “Өнгөрсөн ням гарагт өвөө маань бидэнд ‘Би энэ долоо хоногт үхнэ, тиймээс Томми Монсон руу ярь. Тэр яах ёстойгоо мэднэ’” гэж хэллээ гэв.

Маргааш орой нь би Бремз ах дээр очлоо. Түүнтэй уулзалгүй их удсан байж. Тэр сонсголтгүй болсон учир түүнтэй юм ярьж чадсангүй. Хараагүй болсон байсан учир бичгээр харьцаж ч болсонгүй. Гэр бүлийнхэн нь түүний баруун гарын хуруугаар зүүн гарынх нь алган дээр ирсэн хүний нэрийг үсэглэн бичиж, түүнд мэдэгддэг тухайгаа надад хэлсэн юм. Түүнтэй ярилцах ганц арга нь л тэр байж. Би тэрхүү аргыг ашиглан, хуруугаар нь “Т-О-М-М-И М-О-Н-С-О-Н” гэж бичлээ. Тэр намайг тэгж нэрлэдэг байсан юм. Бремз ах ихэд баярлан, миний гарыг авч толгой дээрээ тавьсан юм. Санваарын адислал хүсэж байгааг нь би ойлгов. Тэр асрах газарт намайг хүргэж ирсэн жолооч бид хоёр Бремз ахын толгой дээр гараа тавин, түүний хүсч буй адислалыг нь өгсөн юм. Бид түүнийг адисалж дуусахад түүний аниастай нүднээс нулимс нь урсан гарч байсан бөгөөд талархлаа илэрхийлэн, бид хоёрын гарыг атгаж билээ. Хэдий Бремз ах түүнийг адисалж байгаа үгсийг сонсож чадаагүй ч гэсэн, Сүнсний хүчтэй мэдэрч, түүний хүсэж байсан адислалыг бид түүнд өгч гэдгийг тэрээр мэдсэн гэдэгт би итгэдэг. Тэр ах харж, сонсож чадахаа больсон байсан. Асрах газрын бяцхан өрөөнөөс өдрөөр ч мөн шөнөөр ч гарах боломж түүнд байдаггүй байсан. Гэсэн хэдий ч түүний инээмсэглэл тодорсон царай мөн хэлсэн үгс нь миний зүрх

сэтгэлд гүн шингэсэн юм. “Та нарт баярлалаа” гээд тэрээр “Тэнгэрлэг Эцэг маань надад сайхан амьдрал өгсөн шүү” гэж хэлж билээ.

Бремз ах зөгнөн хэлснийхээ дагуу тэр долоо хоногтоо нас барсан юм. Тэрээр өөрт нь дутагдаж байсан зүйлээ мартаж, түүнд ирж буй олон адислалдаа талархдаг нэгэн байсан.

Бидэнд хязгааргүй баяр баяслыг өгдөг Тэнгэрлэг Эцэг маань биднийг ирэх зовлон бэрхшээлтэйгээ нүүр тулан, тэдгээрийг ялан дийлснээр илүү ихийг сурч, хөгжиж, улам хүчирхэг болдог гэдгийг маань мэддэг. Биднийг гансруулан, хамаг тэвчээрийг маань барж, зүрхийг маань үхүүлэх уй гашууг мэдрэх үе ирнэ гэдгийг бид мэддэг. Гэхдээ ийм бэрхшээлүүд нь биднийг илүү чадварлаг болгож, бидэнд Тэнгэрлэг Эцэгийн заасны дагуу амьдралаа өөрчлөх боломжийг олгон, биднийг өөрчилдөг билээ. Бид байснаасаа хамаагүй илүү болж, бидний ойлголт тэлж, бусдыг илүү их хайрлах чадвартай мөн өмнөхөөсөө илүү хүчтэй гэрчлэлтэй болцгоодог юм.

Бидний зорилго бол цөхрөлтгүйгээр урагшилж, даван туулах явдал юм. Тийм ээ. Гэхдээ бид бас нар, салхийг сөрөн гарахын тулд сүнсээ хүчирхэгжүүлэх ёстой билээ. Хэрэв бидэнд даван гарах ёстой бэрхшээлүүд мөн шийдэх ёстой асуудлууд байдаггүй байсансан бол бид хэзээ ч өөрчлөгдөхгүй хэвээрээ үлдэж, мөнх амийг авах зорилгодоо ер ойртолгүй эсвэл үл ялиг л ойртсон

байх байсан юм. Нэгэн яруу найрагч энэ санааг дараах шүлгээрээ гаргасан байдаг:

*Хөрөө даах сайн мод амархан
бий болдоггүй,
Хүчтэй салхийг сөрөн, хүч чад-
лаа олж авдаг юм.
Хөх тэнгэрт тэмүүлэн байж,
урт шулуун болж,
Хүчит шуургыг даван бат бөх
болдог юм.
Хүйтэн, халуун, цас, бороонд
хатууржсанаар
Хүн ч тэр, мод ч тэр хүдэр чий-
рэг болдог юм.⁸*

Зөвхөн бидний Эзэн л бидний сорилт, өвчин шаналал, зовлон бэрхшээлийн маань хүнд хүчрийг мэддэг. Зөвхөн Тэр л бидэнд гай зовлонгийн дунд мөнхийн амар амгаланг өгч чадна. Зөвхөн Тэр л бидний шаналж буй зүрх сэтгэлийг маань:

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая.

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

“Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн”⁹ гэх үгсээр тайвшруулж чадна.

Хамгийн сайн сайхан цагт ч тэр, хамгийн муу муухай үед ч гэсэн Тэр бидэнтэй хамт л байдаг. Тэр үргэлж бидэнтэй хамт байна гэж амласан.

Ах, эгч нар минь, бүгдээрээ

амьдралд маань ямар ч муу зүйл тохиолдсон бай хамаагүй бид хэзээ ч Тэнгэрлэг Эцэгээсээ урваж, холдохгүй гэж амлацгаая. Түүнийг санахын тулд асуудал гарахыг бүү хүлээ. Түүнд итгэж найдахын өмнө заавал даруусгагдах шаардлагагүй юм.

Тэнгэрлэг Эцэгтэй ойрхон байхыг хичээцгээе. Ингэхийн тулд Түүнд хандан залбирч, Түүний үгийг өдөр болгон дагах хэрэгтэй. Нар мандаж байна уу, усан боороо цутгаж байна уу ялгаагүй, Тэр бидэнд зайлшгүй хэрэгтэй. Түүний “Би чамайг хаяхгүй, мөн чамайг орхихгүй”¹⁰ гэх үгсийг үргэлж санаж байгаарай.

Зүрх сэтгэлийнхээ бүхий л эрч хүчээр би Бурхан амьд мөн биднийг хайрладаг гэдгийг гэрчилж байна. Түүний Цорын Ганц Хүү бидний төлөө амьдарч мөн үхсэн. Есүс Христийн сайн мэдээ нь амьдралын маань хамгийн харанхуй мөчүүдийг ч гэрэлтүүлэх гэрэл гэгээ болдог. Энэ нь үргэлж мөнхөд хэвээрээ байгаасай хэмээн би Есүс Христийн ариун нэрээр залбирч байна, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. Иеремиа 8:22.
2. Иов 5:7.
3. Иов 1:1.
4. Иов 2:9.
5. Иов 16:19.
6. Иов 19:25.
7. Иошуа 1:5.
8. Дуглас Маллох, “Good Timber,” Стрелинг В. Силл, *Making the Most of Yourself* (1971), 23.
9. Матай 11:28–30.
10. Иошуа 1:5.

Бидэнд зориулсан сургаал

// Бидэнд зориулсан сургаал"-ыг Санваарын анги болон Халамжийн Нийгэмлэгийн хичээлүүдэд сарын дөрөв дэх ням гарагт заана. Хичээл бүрийг хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээр бэлтгэж болно (доорх хүснэгтийг үзнэ үү). Гадас болон дүүргийн ерөнхийлөгчид ашиглах материалаа сонгох буюу бишоп болон салбарын ерөнхийлөгчдөд сонгохыг даалгаж болно. Удирдагчид, Мелкизедек санваартан ах нар болон Халамжийн Нийгэмлэгийн эгч нар ням гарагт ижил хичээл үзэхэд анхаарах хэрэгтэй.

Дөрөв дэх ням гарагийн хичээлд ирж буй хүмүүсийг сүүлд гарсан ерөнхий чуулганы сэтгүүлийг авчирч судлахыг урамшуулна.

Хэлсэн үгсээс хичээлд бэлтгэх зөвлөмжүүд

Хичээлийг судалж, заахад Ариун Сүнс тантай хамт байж

болохын тулд залбир. Та өөр материал ашиглан, хичээлээ бэлдэхийг хүсч болох ч чуулган дээр хэлсэн үгс нь батлагдсан хөтөлбөр юм. Таны үүрэг бол Сүмийн хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр заагдсан сайн мэдээг сурч, түүний дагуу амьдрахад нь бусдад туслах явдал юм.

Материалаа давтан уншиж, ангийн гишүүдийн хэрэгцээнд тохирох зарчмууд болон сургаалыг эрж хай. Түүнчлэн эдгээр үнэнийг заахад тань туслах түүхүүд, судрын эшлэлүүд болон өгүүдэмжийг хэлсэн үгсээс хай.

Зарчмууд болон сургаалыг яаж заахаа тоймло. Ангийн гишүүдээс туслах асуултуудыг асуу:

- Хэлсэн үгсээс зарчим болон сургаалыг хай.
- Тэдгээрийн утгыг тунгаан бод.
- Ойлголт, санаа бодол, туршлага болон гэрчлэлээ хуваалц.
- Эдгээр зарчмууд болон сургаалыг тэдний амьдралтай холбо.

ХИЧЭЭЛҮҮДИЙГ ЗААХ ЁСТОЙ САРУУД	ДӨРӨВ ДЭХ НЯМ ГАРАГИЙН ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛУУД
2013 оны 10-р сар– 2014 оны 4-р сар	2013 оны 10-р сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгс*
2014 оны 4-р сар– 2014 оны 10-р сар	2014 оны 4-р сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгс*

* 4-р сар болон 10-р сарын дөрөв дэх ням гарагийн хичээлдээ хамгийн сүүлийн ерөнхий чуулган эсвэл өмнөх чуулган дээр хэлсэн үгсээс сонгож болно. Эдгээр хэлсэн үгсийг conference.lds.org conference.lds.org хаягаар олон хэлээр унших боломжтой.



Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх

Ирж, бидэнтэй нэгд

Таны нөхцөл байдал, хувийн түүх эсвэл гэрчлэлийн тань хүчирхэг байдал ямар байхаас үл хамааран танд нарт зориулсан орон зай энэ сүмд байна.

Нэг удаа нэгэн эр өөрийгөө дэлхийн бүх шашны цугларсан том танхимд байгаагаар зүүдэлжээ. Шашин бүр хүсүүштэй, олон үнэт зүйлтэй болохыг тэр зүүдэндээ анзаарсан байна.

Тэгээд дараа нь тэрээр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг төлөөлсөн нэгэн найрсаг хостой танилцаж, тэднээс, “Танайх гишүүдээсээ юу шаарддаг вэ?” гэж асуув.

Тэд “Бид юу ч шаарддаггүй ээ,” “Харин *Их Эзэн* биднээс бүхнээ зориулахыг хүсдэг юм” гэв.

Тэд цааш үргэлжлүүлэн, сүмийн дуудлагат ажил, гэрийн болон айлчлагч багш, бүрэн цагийн номлол, долоо хоног бүрийн гэр бүлийн үдэш, халамж болон хүмүүнлэгийн үйлчлэл мөн хичээл заах гэх мэт үүргүүдийн талаар тайлбарлажээ.

Мөнөөх эр “Та нар хийсэн бүх ажлынх нь төлөө хүмүүстээ цалин өгдөг үү?” гэж асуув.

“Өө, үгүй дээ,” “Тэд үнэ хөлсгүйгээр үйлчилдэг юм” хэмээн хосууд тайлбарлав.

“Түүнчлэн” хэмээн хосууд үргэлжлүүлэн, “зургаан сар тутам болдог Ерөнхий чуулганд оролцох эсвэл үзэхийн тулд манай сүмийн гишүүд амралтын өдрүүдийнхээ 10 цагийг зарцуулдаг” хэмээн яриу.

“Хүмүүсийн хэлэх үгсийг арван цаг сонсдог гэж үү?” хэмээн тэр гайхсанаа,

“Тэгвэл долоо хоног бүр болдог сүмийн цуглаан чинь хэр удаан үргэлжилдэг вэ?” хэмээн асуув.

“Ням гараг бүр гурван цаг!”

“Хөөх, тийм үү” хэмээн эрэгтэй дуу алдан, “Танай сүмийн гишүүд та нарын хэлсэн бүхнийг хийдэг гэж үү? хэмээн асуув.

“Тэдгээрээс гадна бүр ихийг хийдэг. Бид гэр бүлийн түүхийн ажил, өсвөр үеийнхний чуулган, галын дэргэдэх ярилцлага, судраас судлах, удирдагчдын сургалт, өсвөр үеийнхэнд зориулсан үйл ажиллагаанууд, өглөөний семинар, сүмийн байрыг цэвэрлэх, түүнчлэн мэдээж Их Эзэний эрүүл мэндийн хууль, гачигдаж буй хүмүүст туслахад зориулдаг сар тутмын мацаг барилт,

аравны нэг зэргийн талаар дурдаагүй шүү дээ.”

Өнөөх эр “Одоо би бүр гайхчихлаа. Хүмүүс яагаад ийм сүмд нэгдэхийг хүсдэг байна?” гэв.

Хосууд инээмсэглэн, “Бид таныг ингэж асуухгүй нь гэж бодлоо” хэмээв.

Хүмүүс яагаад ийм сүмд нэгдэхийг хүсдэг юм бол?

Дэлхий даяар өөр олон сүмийн гишүүдийн тоо буурч байхад Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бусад олон сүмүүдтэй харьцуулахад цөөхөн ч гэлээ дэлхий дээрх хамгийн хурдацтай өсч буй сүмүүдийн нэгд ордог юм. 2013 оны 9-р сарын байдлаар сүм дэлхий даяар 15 сая гаруй гишүүнтэй болсон байна.

Үүнд олон шалтгаан байгаа ч цөөн хэдийг нь би дурдъя.

Аврагчийн Сүм

Нэгдүгээрт, Есүс Христ өөрөө энэ сүмийг бидний энэ эрин үед сэргээсэн юм. Та эндээс Түүний нэрээр үйлдэх буюу нүглүүдийн өршөөлийн төлөөх баптисм болон Ариун Сүнсний бэлэг хүртгээх, газар мөн тэнгэрт лацдан холбох эрх мэдлийг олох болно.¹

Энэ сүмд нэгдсэн хүмүүс Аврагч Есүс Христэд хайртай бөгөөд Түүнийг дагахыг хүсдэг юм. Бурхан хүн төрөлхтөнтэй ахин ярьдаг хэмээх мэдлэгт тэд баясдаг. Тэд ариун санваарын ёслолуудыг хүлээн авч, Бурхантай гэрээ байгуулах үедээ өөрсдийн амьдралд Бурханы хүчийг мэдэрдэг.² Ариун сүмд орохдоо тэд Түүний оршихуйд байгаагаа ойлгодог билээ. Тэд

ариун судруудаас³ уншиж, Түүний бошиглогчдын заасан зүйлийн дагуу амьдрахдаа өөрсдийн ихэд хайрладаг Аврагчид илүү ойрхон болж, өсч хөгждөг.

Бодит итгэл

Сүм биднийг сайныг үйлдэх боломжуудаар хангадаг нь хоёр дахь шалтгаан юм.

Бурханд итгэх нь сайшаалтай боловч ихэнх хүмүүс сүнслэг удирдамж бүхий сургаалыг сонсох эсвэл тэнгэрт байрлах өөрсдийн харшийн⁴ талаар мөрөөдөхөөс илүү ихийг хийхийг хүсдэг. Тэд итгэлээ бодит үйлдэл болгохыг мөн ханцуй шамлан, энэхүү агуу үйлсэд оролцохыг хүсдэг.

Тэд бидэнтэй нэгдэх үед эдгээр зүйлс-авьяас чадвар, энэрэл хайр, цаг заваа сайн үйлс хийхэд зориулах олон боломж тэдэнд бий болох болно. Дэлхий даяар явагддаг цуглаануудад санваартнууд маань цалин хөлс авдаггүй учраас манай гишүүд өөрсдөө үйлчлэл хийдэг юм. Тэд сүнслэг удирдамжаар дуудагддаг. Заримдаа бид өөрсдийн саналаар, заримдаа “*бусдын саналаар*” ч хийнэ. Бид оногдсон үүргээ ачаа дарамт гэж боддоггүй бөгөөд харин Бурхан болон Түүний хүүхдүүдэд үйлчлэхийн тулд баяр баясалтайгаар хийдэг гэрээгээ гүйцэлдүүлэх боломж гэж хардаг билээ.

Эрхэм үнэт адислалууд

Хүмүүсийн энэ сүмд нэгдэх гурав дахь шалтгаан бол дагалдагчийн замаар алхсанаар үнэт адислалууд руу хөтөлдөгт оршино.

Баптисм бол дагалдагчийн замаар аялах эхлэлийн цэг гэж бид үздэг. Өдөр тутам Есүс Христтэй хамт алхах бидний аялал нь энэ амьдралын зорилго болох амар амгалан, ирэх дэлхий дэх бүрэн дүүрэн аз жаргал, мөнхийн аврал руу удирддаг.

Энэхүү замыг итгэлтэйгээр дагадаг хүмүүс амьдралын олон алдаа төөрөгдөл, харамсал гуниг, гэмшил зовлонгоос хол байж чаддаг.

Сүнсэн дотроо ядуу, зүрх сэтгэлдээ шударга хүмүүс эндээс мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг олдог.

Зовж шаналж, гуниглан, гашуудаж байгаа хүмүүс эндээс мөн эдгэрлийг олдог.

Нүглийнхээ ачааг үүрч байгаа хүмүүс эндээс өршөөл, эрх чөлөө, амралтыг олж авдаг.

Холдон явсан хүмүүс

Үнэний эрэл нь сая сая хүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм рүү хөтөлсөн. Гэсэн хэдий ч, нэгэн үед хайртай байсан сүмээсээ холдон явсан хүмүүс бас байдаг.

“Сургаал тийм гайхалтай юм бол хүмүүс яагаад холдон явдаг юм бэ?” гэж асуух хүн байж болно.

Заримдаа бид тэдгээр хүмүүсийг гомдсон, залхуурсан эсвэл нүгэл үйлдсэнээс болоод холдсон байх гэж боддог. Үнэндээ, энэ нь тийм ч энгийн зүйл биш юм. Чухамдаа, олон янзын нөхцөл байдалд тохирох ганцхан шалтгаан гэж байхгүй.

Хайртай гишүүдийн маань зарим нь сүмээс өөрсдийгөө тусгаарласан нь дээр юм болов уу хэмээх асуултыг тавин, олон жилийн турш дотроо бодон, шаналж явдаг.

Асуулт асуун, түүнийхээ хариулыг олж авсан залуу хүүгээр дамжуулан сэргээгдсэн, хувийн сонгох эрхийг чанд эрхэмлэдэг энэ сүмд үнэнийг эрхэмлэн хайдаг хүмүүсийг бид хүндэлдэг. Аялал нь тэднийг бидний хайрладаг сүм болон бидний олж мэдсэн тэрхүү үнэнээс хөндийрүүлэхэд зүрх сэтгэл маань шимширдэг ч ухамсрынхаа дагуу Бүхнийг Чадагч Бурханаа шүтэх эрх нь бидэнд байгаа онцгой эрх хэмээн зарладаг шигээ бид бусдын тэр эрхийг хүндэлдэг.⁵

Хариулагдаагүй асуултууд

Зарим хүмүүс өнгөрсөн үед хийгдсэн болон хэлэгдсэн зүйлсийн тухай хариулагдаагүй зарим асуултуудын талаар шаналсаар байдаг. Сүнслэг өдөөлт бүхий,

хүндлүүштэй, тэнгэрлэг олон үйл явдлыг багтаасан сүмийн сүүлийн 200 жилийн түүхэнд хүмүүсийн оюунд асуулт бий болгоход хүргэсэн зарим зүйлс хэлэгдэж, хийгдсэн гэдгийг бид нээлтэй хүлээн зөвшөөрдөг.

Заримдаа бидэнд ердөө л бүх мэдээлэл байхгүйн улмаас асуултууд гарч ирдэг бөгөөд бидэнд бага зэрэг илүү тэвчээр хэрэгтэй болдог. Бүх үнэн яваандаа илэрч, мэдэгдэхэд өмнө нь бидэнд ойлгомжгүй байсан зүйлс бидний санаанд хүрэхүйцээр ойлгомжтой болох болно.

Зарим үед “баримт” гэж яг юу болох тухай олон өөр үзэл гардаг. Нарийвчилсан судалгаанаас харахад зарим хүмүүст эргэлзээ төрүүлдэг асуултууд нь бусад хүмүүсийн итгэлийг бэхжүүлж ч болно.

Төгс бус хүмүүсийн алдаа

Шулуухан хэлэхэд сүмийн гишүүд эсвэл удирдагчид алдаа гаргах үе бий. Бидний эрхэмлэн үздэг үнэт зүйлс, зарчим юм уу сургаалуудтай зохицохгүй хэлэгдсэн эсвэл хийгдсэн зүйлс байж болно.

Сүм төгс хүмүүсээр удирдагдсан бол төгс байх байсан гэж би төсөөлж байна. Бурхан төгс бөгөөд Түүний сургаал ариун юм. Гэхдээ Тэр биднээр—Өөрийн төгс бус хүүхдүүдээр—алдаа гаргадаг төгс бус хүмүүсээр дамжуулан ажилладаг билээ.

Мормоны Номын эхний хуудаснаас бид “Мөн эдүтээ, хэрэв буруу буй бөгөөс тэдгээр нь хүмүүний алдаа бөлгөө; иймийн тул, та нар Христийн шүүлтийн суудлын өмнө толбогүй байж болохын тулд, Бурханы зүйлүүдийг бүү буруушаа”⁶ хэмээн уншдаг.

Ийм л байсан бөгөөд Христ дэлхий дээр Өөрийн биеэр хаанчлах тэрхүү төгс өдрийг хүртэл ийм л байх болно.

Хүмүүний гаргасан алдаанаас болж зарим хүмүүс бүдэрдэг нь харамсалтай. Гэвч үүнийг үл хайхран Есүс Христийн Хожмын Үеийн

Гэгээнтнүүдийн Сүмд байдаг сэргээгдсэн сайн мэдээний мөнхийн үнэн гутаагдахгүй, сулрахгүй мөн устгагдахгүй.

Би Их Эзэн Есүс Христийн төлөөлөгч бөгөөд энэ сүмийн ажил мөн зөвлөлийг шууд харж буй хүний хувьд энэ сүм болон сүмийн гишүүдэд нөлөөлөх ач холбогдол бүхий ямар ч шийдвэрийг Мөнхийн Эцэгийн сүнслэг өдөөлт, удирдамж, зөвшөөрлийг хичээнгүйлэн эрэлхийлэхгүйгээр гаргадаггүй гэдгийг албан ёсоор гэрчилж байна. Энэ бол Есүс Христийн сүм. Бурхан Өөрийн сүмийг томилогдсон замаас хазайхыг эсвэл тэнгэрлэг хувь заяагаа гүйцэлдүүлж чадахгүй болохыг зөвшөөрөхгүй.

Энд таны орон зай байгаа

Сүмээс өөрсдийгөө хөндийрүүлсэн хүмүүст хандан, хайрт найзууд минь, танд зориулсан газар энд байна хэмээн хэлье.

Ирж; авьяас чадвар, бэлэг оюун болон эрч хүчээ биднийх дээр нэмээч. Үр дүнд нь бид бүгдээрээ илүү их сайжрах болно.

Зарим нь “Тэхдээ миний эргэлзээ яах вэ?” гэж асууж магадгүй.

Асуулттай байна гэдэг нь хэвийн зүйл юм чин сэтгэлийн асуултын жижиг үр ихэнхдээ соёолж, ойлголтын агуу том мод болон ургадаг. Ноцгой эсвэл эмзэг асуултуудын талаар хэзээ нэгэн цагт эргэлзэж байгаагүй сүмийн гишүүд цөөхөн байдаг. Сүмийн зорилгуудын нэг бол зарим үед итгэлийн үрийг—бүр эргэлзээ бүхий болон итгэлгүй байдлын элсэрхэг хөрсөнд тарьж, арчилж ургуулах явдал ч байдаг. Итгэл бол үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах нь юм.⁷

Тиймийн тул, хайрт ах эгч нар—найз нөхөд минь—итгэлдээ эргэлзэхээсээ өмнө эргэлзээндээ эргэлз.⁸ Эргэлзээ биднийг олзлон, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин ирдэг хайр, амар амгалан, бэлгүүдээс маань холдуулахыг бид хэзээ ч зөвшөөрч болохгүй.

Зарим хүмүүс “Би энэ сүмд, та

нар шиг хүмүүсийн дунд тохирохгүй ээ” гэж хэлж магадгүй.

Та бидний зүрх сэтгэл рүү өнгийн харж чаддаг бол өөрийнхөө бодож байгаагаас ч илүү сайн тохирч байгаагаар олж харах байх. Танд тохиолддог уйтгар гуниг, зовлон зүдгүүр болон найдвар бидэнд ч бас байдгийг олж хараад та гайхаж магадгүй. Ар гэр эсвэл хүмүүжил тань олон хожмын үеийн гэгээнтнээс анзаарсан зүйлсээс тань өөр мэт санагдаж болно, гэхдээ тэр нь адислал байж болох юм. Ах эгч нар болон хайрт найзууд аа, та нарын онцгой авьяас чадвар, чадамж бидэнд хэрэгтэй. Дэлхийн бөмбөрцгийн эргэн тойрон дахь хувь хүн болон бүлэг хүмүүсийн онцлог талууд нь энэ сүмийн хүчирхэг байдал юм.

Зарим хүмүүс, “Би танай жишигт хүрэхүйцээр амьдарч чадахгүй байх” гэж хэлж болох юм.

Ирэх бас нэг шалтгаан! Төгс бус, зовж шаналж буй мөн ядарсан хүмүүсийг халамжлахын тулд сүм байгуулагдсан. Зарлигуудыг дагахдаа хараахан *төгс болоогүй* ч бүхий л зүрх сэтгэлээрээ дагахыг хүсдэг хүмүүсээр сүм дүүрсэн байдаг.

Зарим нь “Би танай сүмийн хоёр нүүр гаргадаг гишүүнийг мэднэ. Түүн шиг гишүүнтэй сүмд би хэзээ ч нэгдэж чадахгүй” гэж хэлж магадгүй.

Хэрвээ та итгэж буй зүйлийнхээ дагуу төгс амьдарч чадалгүй унасан хүнийг *хоёр нүүртэн* хэмээн тодорхойлж байгаа бол бид бүгдээрээ хоёр нүүртэн болно. Бид Христтэй адил байх хэрэгтэй гэдгээ мэдэж байгаа ч хэн маань ч хараахан адил биш юм. Гэвч бид өөрсдийн алдаа болон нүгэл үйлдэх хандлагаа орхихыг чин сэтгэлээсээ хүсдэг. Есүс Христийн цагаатгалын тусламжтайгаар бид илүү сайн хүмүүс болохыг бодгал, зүрх сэтгэлээсээ эрмэлздэг.

Хэрвээ энэ нь таны хүсэл бол нөхцөл байдал, хувийн түүх эсвэл гэрчлэлийн тань хүчирхэг байдал ямар байх нь хамаагүй танд

зориулсан орон зай энэ сүмд байна. Ирж, бидэнтэй нэгдээрэй!

Ирж, бидэнтэй нэгд!

Хүмүүний төгс бус байдлыг үл хайхран, энэ сүмийн гишүүдийн дундаас энэ дэлхийн санал болгох хамгийн эрхэм сайн олон хүнийг та олох болно гэдэгт би итгэлтэй байна. Есүс Христийн сүм элэгсэг дотно, хүнлэг энэрэнгүй, шударга зөв, ажилч хичээнгүй байдлаараа анхаарал татдаг мэт санагддаг.

Хэрвээ та эндээс төгс хүнийг олно гэж бодож байгаа бол урам тань хугарах болно. Харин Христийн ариун сургаал, “шархадсан зүрх сэтгэлийг эдгээгч”⁹ Бурханы үг болон Ариун Сүнсний цэвэршүүлэгч нөлөөг хайж байгаа бол эндээс та олох болно. Бөхөж буй итгэлийн энэ үед—олон хүн тэнгэрийн тэврэлтээс өөрсдийгөө холдуулж байгаа энэ үед—яг л тан шиг Бурхан болон найз нөхдөдөө үйлчилснээр Аврагчдаа илүү ойртон очихоор, Түүнийг мэдэхээр тэмүүлж буй хүмүүсийг та олох болно. Ирж, бидэнтэй нэгдээрэй!

Та нар бас явахыг хүсэж байна уу?

Аврагчийн амьдрал дахь олон хүн Түүнийг орхин явсан үе миний санаанд орж байна.¹⁰ Есүс арванхоёр шавиасаа:

“Та нар бас явахыг хүсэж байна уу?” хэмээн асуухад

“Симон Петр Түүнд Эзэн, бид хэн рүү явах юм бэ? Мөнх амийн үгс Танд байна”¹¹ хэмээн хариулдаг.

Энэ асуултад хариулах үе бидэнд ч бий. Бид бас холдон явах уу? Эсвэл бид Петртэй адил мөнх амийн үгсээс зууран барих уу?

Хэрэв та үнэн, утга учир, итгэлээ үйлдэл болгох арга замыг хайж байгаа бол, хэрэв та өөрийн байх ёстой газраа хайж байгаа бол: Ирж, бидэнтэй нэгдээрэй!

Хэрэв та нэгэн цагт сонгож байсан итгэлээсээ холдсон байгаа бол: Эргэн ирж, бидэнтэй нэгдээрэй!

Хэрэв та бууж өгөх гэж байгаа бол: Дахиад жаахан тэсээрэй. Танд

зориулсан орон зай энд байна.

Эдгээр үгсийг сонсож эсвэл уншиж байгаа бүхий л хүмүүсийг: Ирж, бидэнтэй нэгдээч. Эелдэг зөөлөн Христийн дуудлагад анхаарлаа хандуулаач. Загалмайгаа үүрч, Түүнийг дагаач¹² хэмээн би гуйж байна.

Ирж, бидэнтэй нэгдээрэй! Учир нь эндээс та үнэлж боломгүй үнэ цэнэтэй зүйлээ олох болно.

Та эндээс мөнх амийн үгс, адислагдсан гэтэлгэлийн амлалт, амар амгалан болон аз жаргалд хүрэх замыг олох болно хэмээн би гэрчилж байна.

Үнэнийг эрэлхийлэх таны эрэл нь ирж, бидэнтэй нэгдэх хүслээр зүрх сэтгэлд тань нөлөөлөх болтугай хэмээн би чин сэтгэлээсээ залбирч байна. Есүс Христийн ариун нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Матай 16:18–19; Хиламан 10:7 –г үзнэ үү.
2. Сургаал ба Гэрээ 84:20-ийг үзнэ үү.
3. 2 Нифай 33:10-ыг үзнэ үү.
4. “Өнөөдөр би энэ дэлхийд ямар нэг сайн юм хийв үү?” *Hymns*, дугаар. 223-ыг үзнэ үү.
5. Итгэлийн Тунхаг 1:11-ийг үзнэ үү.
6. Мормоны Номын нүүр хуудас; Мормон 8:17-г үзнэ үү.
7. Еврей 11:1; Алма 32:21-ийг үзнэ үү.
8. Ф. Ф. Босворт, *Christ the Healer* (1924), 23-ыг үзнэ үү.
9. Иаков 2:8
10. Иохан 6:66-г үзнэ үү.
11. Иохан 6:67–68.
12. Матай 16:24-ийг үзнэ үү.